



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл давтан олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/98 дугаар тушаал “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын хоёрдугаар хавсралтын 2.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг давтан олгох гадаадын эмнэлгийн 3 мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Эрдэнэтуяа/-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141223899

Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
 06 дугаар сарын 0... өдрийн  
 №... дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ДАВТАН ОЛГОХ  
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1	Танилгучи Ёшишигэ	Япон	Бабуно Мирай эмнэлэг	-	ГЭ0002738	Нүүр амны мэс засал судлал	Эмчлэх	4 өдөр 2023.06.08 2023.06.11
2	Сатоши Накагава	Япон	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	-	ГЭ00002736	Эрчимт эмчилгээ судлал	Эмчлэх	5 өдөр 2023.06.09 2023.06.13
3	Сэйсүкэ Сакамото	Япон	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	-	ГЭ00002737	Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал судлал	Эмчлэх	5 өдөр 2023.06.09 2023.06.13